**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2026/006/НА-СТА-ОНТ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025.02.25 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: NarangerelB@audit.gov.mn<br>Ахлах аудитор Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn<br>Аудитор Д.Даваадорж<br>Утас: 90119422 Цахим хаяг: davaadorjd@audit.gov.mnЦахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 3

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **919,841,719.20** | **1,035,569,584.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 426,636,183.20 | 637,969,584.20 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 426,636,183.20 | 637,969,584.20 |
| **3121** | **Төгрөг** | 426,636,183.20 | 637,969,584.20 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 426,636,183.20 | 637,969,584.20 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 493,205,536.00 | 397,600,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 493,205,536.00 | 397,600,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 493,205,536.00 | 397,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **919,841,719.20** | **1,035,569,584.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **453,825.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 453,825.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 453,825.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 453,825.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **919,841,719.20** | **1,035,115,759.20** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 919,841,719.20 | 1,035,115,759.20 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 919,841,719.20 | 1,035,115,759.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 919,841,719.20 | 919,841,719.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 115,274,040.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **919,841,719.20** | **1,035,569,584.20** |

### 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **750,755,800.00** | **804,589,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **113,611,200.00** | **123,750,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 113,611,200.00 | 13,750,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 113,611,200.00 | 13,750,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 78,611,200.00 | 13,750,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000,000.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 110,000,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 110,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **637,144,600.00** | **680,839,300.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 58,234,400.00 | 73,501,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 58,234,400.00 | 73,501,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 578,910,200.00 | 607,337,800.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 578,910,200.00 | 607,337,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **575,237,500.00** | **689,315,260.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **575,237,500.00** | **689,315,260.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 575,237,500.00 | 689,315,260.00 |
| 220001 | Барилга байгууламж | 575,237,500.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 689,315,260.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **175,518,300.00** | **115,274,040.00** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **175,518,300.00** | **115,274,040.00** |

## 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **750,755,800.00** | **804,589,300.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **113,611,200.00** | **123,750,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 113,611,200.00 | 13,750,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 113,611,200.00 | 13,750,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 78,611,200.00 | 13,750,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000,000.00 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 110,000,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 110,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **637,144,600.00** | **680,839,300.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 637,144,600.00 | 680,839,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 58,234,400.00 | 73,501,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 578,910,200.00 | 607,337,800.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **750,755,800.00** | **804,589,300.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **518,170,353.80** | **593,255,899.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **518,170,353.80** | **593,255,899.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 518,170,353.80 | 593,255,899.00 |
| 220001 | Барилга байгууламж | 518,170,353.80 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 00.00 | 593,255,899.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-518,170,353.80** | **-593,255,899.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 232,585,446.20 | 211,333,401.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 194,050,737.00 | 426,636,183.20 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 426,636,183.20 | 637,969,584.20 |

## 1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **919,841,719.20** | **00.00** | 919,841,719.20 |
| D01 | **2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **919,841,719.20** | **00.00** | 919,841,719.20 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **919,841,719.20** | **00.00** | 919,841,719.20 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 115,274,040.00 | 00.00 | 115,274,040.00 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **1,035,115,759.20** | **00.00** | 1,035,115,759.20 |

## 1.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр

| **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|
| | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,143,695,900.0** | **1,231,225,483.2** | (87,529,583.2) | 107.65 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **697,059,800.0** | **680,839,300.0** | 16,220,500.0 | 97.67 |
| Орон нутгийн төсвөөс | 80,152,900.0 | 73,501,500.0 | 6,651,400.0 | 91.70 |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 616,906,900.0 | 607,337,800.0 | 9,569,100.0 | 98.45 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **426,636,100.0** | **13,750,000.0** | 412,886,100.0 | 3.22 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 13,750,000.0 | (13,750,000.0) | - |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - | - | - |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 426,636,100.0 | 426,636,183.2 | (83.2) | 100.00 |
| **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | **20,000,000.0** | **110,000,000.0** | (90,000,000.0) | 550.00 |
| Хандив тусламж /дотоод/ | 20,000,000.0 | 110,000,000.0 | (90,000,000.0) | 550.00 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,143,695,900.0 | 593,255,899.0 | 550,440,001.0 | 51.87 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,143,695,900.0 | 593,255,899.0 | 550,440,001.0 | 51.87 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,143,695,900.0 | 593,255,899.0 | 550,440,001.0 | 51.87 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,143,695,900.0** | **593,255,899.0** | 550,440,001.0 | 51.87 |
| **Дотоод эх үүсвэрээр** | 1,143,695,900.0 | 593,255,899.0 | 550,440,001.0 | 51.87 |
| Бусад хөрөнгө | 1,143,695,900.0 | 593,255,899.0 | 550,440,001.0 | 51.87 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 426,636,183.2 | - | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 637,969,584.2 | - | - |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 366,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 366,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлэв.

### 2.1 Албан шаардлага

2.1.1 Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан “Сумын инженерийн шугам сүлжээ, сургууль, дотуур байрны зураг төсөв боловсруулах” төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан “Поли Лайн Констракшн” ХХК-тай сумын Засаг дарга 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 308,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, тайлант онд 281,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гэвч гэрээнд заасан ажлын гүйцэтгэлийн хугацаа 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр дууссан байхад гэрээт ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Бөмбөгөр сумын Засаг дарга болон “Поли Лайн Констракшн” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний 1.4 дэх заалт “гэрээний хугацаа нь 2025 оны 05 дугаар сарын 23-аас 2025 оны 07 дугаар сарын 28 хүртэл”, 4.3 дахь заалт “гэрээт ажлын зураг төслийг чанарын шаардлага хангасан түвшинд хийж гүйцэтгэн, гэрээнд заасан хугацаанд захиалагч талд хүлээлгэн өгнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бөмбөгөр сумын засаг дарга, “Поли Лайн Констракшн” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

2.1.1 Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Мал угаалгын ванн барих” төсөл, арга хэмжээний хүрээнд сумын Засаг дарга Хөх толгойн 2 дугаар багт хэрэгжүүлэх ажлыг “Препер кран” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр 29,500.0 мянган төгрөгийн, Бургас 3 дугаар багт хэрэгжүүлэх ажлыг “Арвай шижир” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр 28,500.0 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна.

Гэрээнд заасан урьдчилгаа төлбөрийн санхүүжилтэд дээр 2 компанид нийт 28,800.0 мянган төгрөгийг олгосон боловч гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна. Тухайлбал: ажлын гүйцэтгэлийн хугацаа “Препер кран” ХХК-тай байгуулсан гэрээнд 2025 оны 11 дүгээр сарын 15, “Арвай шижир” ХХК-тай байгуулсан гэрээнд 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр дуусахаар заасан боловч гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэж, хүлээн аваагүй байна.

Энэ нь Бөмбөгөр сумын Засаг дарга болон “Препер кран Констракшн” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний 2.4 дэх заалт “ажил дуусах хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 15”, 5.1 дэх заалт “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасны дагуу чанарын шаардлага хангасан түвшинд хийж гүйцэтгэнэ”, мөн “Арвай шижир” ХХК-тай байгуулсан гэрээний 2.4 дэх заалт “ажил дуусах хугацаа 2025 оны 10 дугаар сарын 01”, 5.1 дэх заалт “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг хангаж ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авах албан шаардлагыг хүргүүлэв.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан “Сумын инженерийн шугам сүлжээ, сургууль, дотуур байрны зураг төсөв боловсруулах” төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан “Поли Лайн Констракшн” ХХК-тай сумын Засаг дарга 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 308,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, тайлант онд 281,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гэвч гэрээнд заасан ажлын гүйцэтгэлийн хугацаа 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр дууссан байхад гэрээт ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөөгүй байна | 1 | 308,000.0 | | | 1 | 308,000.0 | | | | | | |
| “Препер кран” ХХК-тай байгуулсан гэрээнд 2025 оны 11 дүгээр сарын 15, “Арвай шижир” ХХК-тай байгуулсан гэрээнд 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр дуусахаар заасан боловч гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэж, хүлээлгэн өгөөгүй байна. | 1 | 58,000.0 | | | 1 | 58,000.0 | | | | | | |
| Нийт зөрчлийн дүн | 1 | 366,000.0 | | | | 366,000.0 | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | | | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | 1 | | 1 | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | 1 | | 1 | | | | | |

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 135/А057/255/БНА-2026-006 — ПА-СТА-ТШЗ. Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөмбөгөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Мал угаалгын ванн барих" төсөл, арга хэмжээний хүрээнд сумын Засаг дарга Хөх толгойн 2 дугаар багт хэрэгжүүлэх ажлыг "Препер кран" ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр 29,500,000 (Хорин есөн сая таван зуун мянга) төгрөгийн, Бургас 3 дугаар багт хэрэгжүүлэх ажлыг "Арвай шижир" ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр 28,500,000 (Хорин найман сая таван зуун мянга) төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна. Уг гэрээнүүдийг гэрээнд заасан ажлын гүйцэтгэлийн хугацааг шалгаж үзэхэд "Препер кран" ХХК-тай байгуулсан гэрээний ажлын гүйцэтгэлийн хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 15, "Арвай шижир" ХХК-тай байгуулсан гэрээний ажлын гүйцэтгэлийн хугацааг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл байхаар тус тус заасан боловч гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Бөмбөгөр сумын Засаг дарга болон "Препер кран Констракшн" ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний 2.4 дэх заалт "ажил дуусах хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 15", 5.1 дэх заалт "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасны дагуу чанарын шаардлага хангасан түвшинд хийж гүйцэтгэнэ", мөн "Арвай шижир" ХХК-тай байгуулсан гэрээний 2.4 дэх заалт "ажил дуусах хугацаа 2025 оны 10 дугаар сарын 01", 5.1 дэх заалт "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

0428000438

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бөмбөгөр сумын засаг дарга, “Препер кран Констракшн”, “Арвай шижир” ХХК нарын хооронд байгуулсан нийт 58,000,000 (Тавин найман сая)төгрөгийн гэрээний хэрэгжилтийг хангуулж нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөмбөгөр сумын Засаг дарга Н.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Ж.Сэржмядаг нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ДАВААДОРЖ

6417143544
БЮА0067 9007423

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 166/А057/255/БНН-2026-006-НА-СТА-ТШЗ Номгон

## Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөмбөгөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан “Сумын инженерийн шугам сүлжээ, сургууль, дотуур байрны зураг төсөв боловсруулах” төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан “Поли Лайн Констракшн” ХХК-тай сумын Засаг дарга 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 308,000,000 (Гурван зуун найман сая) төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэрээнд заасан ажлын гүйцэтгэлийн хугацаа 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр дууссан боловч уг ажил, үйлчилгээг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Бөмбөгөр сумын Засаг дарга болон “Поли Лайн Констракшн” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний 1.4 дэх заалт “гэрээний хугацаа нь 2025 оны 05 дугаар сарын 23-аас 2025 оны 07 дугаар сарын 28 хүртэл”, 4.3 дахь заалт “гэрээт ажлын зураг төслийг чанарын шаардлага хангасан түвшинд хийж гүйцэтгэн, гэрээнд заасан хугацаанд захиалагч талд хүлээлгэн өгнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бөмбөгөр сумын засаг дарга, “Поли Лайн Констракшн” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулж нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

0426030442

2. Цаашид алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөмбөгөр сумын Засаг дарга Н.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Ж.Сэржмядаг нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ДАВААДОРЖ

6417143544
БЮА0067 9007423

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно